



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/21

Чингис хот

**Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх тухай**

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлчилгээ, гэр бүлийн хэрэгцээ, өвөлжөө хаваржааны зориулалттай газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн өргөдөл гаргасан иргэн Б.Зоригтбаатар, Д.Лхагвасүрэн нарын холбогдох бичиг баримтыг үндэслэн газар эзэмших эрхийн гэрчилгээг 1 дүгээр хавсралтад дурдсанаар 2 иргэний 2 нэгж талбарыг шилжүүлсүгэй.


2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэдэд газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, гэрээ байгуулан биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын мэргэжилтэн Ц.Зулжаргалд үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор сумын Засаг даргын 2015 оны а/146 дугаар, 2022 оны а/02 дугаар захирамжийн дээрх иргэдэд холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

ДАРГА

Д.ЭРДЭНЭБААТАР

Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны
01 дугаар сарын 09-ны өдрийн 174
дугаар захирамжийн хавсралт



Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх нэрсийн жагсаалт

Д/д	Шилжүүлсэн хүний эцэг/эх/-ийн нэр, нэр	Газрын зориулалт	Газрын хэмжээ	Эзэмшил газрын байршил	Шилжүүлэн авсан иргэн ААНБ-ын нэр	Хугацаа	Шилжүүлэх үндэслэл
1	Баямаа Зоригтбаатар /СЭ75041271/	Үйлчилгээ	5000 м2	Хэнтий, Хэрлэн 7-р баг, Номгон Захирагчийн ажлын албаны зүүн урд	Пүрэвжав Лутгаа / СШ75121618/	5	Эрх шилжүүлэх гэрээ
2	Дэмбэрэл Лхагвасүрэн /СНО54070769/	Өвөлжөө, хаваржаа	10000м2	Хэнтий, Хэрлэн 7-р баг Номгон, Жаал булаг	Далхжав Алтанбагана /ДО76082611/	12	Эрх шилжүүлэх гэрээ